



**“ДҮТ - ДЦСЗ ХОЛБООНЫ ГАЗАР ДООГУУРХ ХУДАГ, СУВАГЧЛАЛЫГ
ЗАСВАРЛАХ” АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ,
ТАВИГДАХ ШААРДЛАГА**

Үндэслэл:

Эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг зохицуулагч шуурхай удирдлагаар хангагч Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн онцлог нь үйлдвэрлэх, дамжуулах түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудтай өөрийн бие даасан хараат бус сүлжээтэй байдаг ба энэ нь найдвартай тасралтгүй байх үүрэгтэй байдаг. Бие даасан шилэн кабелийн холбоо, сүлжээний үндэс суурь нь газар доорх инженерийн байгууламж болох худаг, сувагчлал юм. ДҮТ - ДЦСЗ хоорондох холбооны худаг сувагчлал нь гадны нөлөө болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас худгийн таг эвдэрсэн, дарагдсан, алдагдсан зэрэг нөхцөл байдал үүссэн тул үүнийг засварлах, сэргээх ажлыг хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

Байршил:

ДҮТ ТӨХХК-аас ДЦС-3 ТӨХК хоорондох худаг сувагчлал, ДҮТ – УБДС – Дохиолол холбооны 2-р анги

Холбооны худаг , сувагчлалын одоогийн байдал:

ДҮТ ТӨХХК –ийн байрнаас ДЦС-3 ТӨХК хүртэл газар доогуурх холбооны худаг сувагчлал нь 1.0-1.2 метрийн газрын гүнд абцесто цементэн 2 эгнээ, 110 мм хоолойтой, нийт 34 (Худгийн дугаар №26-аас №59 хүртэл) ширхэг дунд зэргийн стандартын худагтай. Худаг хоорондын нисэлтийн зай 19 - 140 метр. ДҮТ-ДЦСЗ хооронд холбооны худаг, сувагчлалын тойм зураг.

Зарим холбооны худгийн таг нь 10мм зузаантай төмөр лист төмрөөр тагласан. Төмөр лист таганд гаргасан 25мм-ийн диаметртэй 4 нүхээр худгийн дотор талын төмөр хийцэд гагнаж бэхэлсэн 20мм –ийн диаметртэй арматур төмрийг гарган гагнаж нээгдэхгүй болгож бэхэлж гагнасан. Худгийн таган дээр 1200х1200х150мм хэмжээтэй бетон цутгаж битүүмжлэгдсэн.



Угсралт, суурилуулалтын ажлын даалгавар:

- ДҮТ - ДЦСЗ хүртэлх нийт 34 ширхэг холбооны худгуудын тагыг нээх, зарим худагт хуримтлагдсан хог шороог цэвэрлэх.
- Нийт 34 ширхэг худгуудаас авто замын ойролцоо байх худгийн хүзүүг газрын түвшинтэй зэрэгцээ болгох.
- Худгуудийн хооронд сүмбэ сүвлэж эвдэрч гэмтсэн, засварлах шаардлагатай сувагчлалын цэгийг тодорхойлох, түүнийг засварлах.
- Худгуудын тагийг нээх, хаах боломжтойгоор түгжээ хийх, таган дээр дугаар тэмдэглэгээ хийх (төмөр нугастай, болт, гайкаар чангалах боломжтой байх, гүйцэтгэгч нь захиалагчтай тохиролцож өөр оновчтой хувилбараар шийдвэрлэж болно)
- Холбооны сувагчлалын трассын дагуу шороонд дарагдаж үзэгдэхгүй болсон худгуудыг ил гаргах, дугаар тэмдэглэгээ хийх.
- Худгийн таг үрэгдсэн байршлуудад худгийн тагийг хүзүүвчтэй нь солих.
- ДҮТ – УБДС – Дохиолол холбооны 2-р анги хүрэх шилэн кабелийн гэмтэлтэй цэгийг тодорхойлох, шилэн кабель татаж холболт хийх.

Бусад техникийн шаардлагууд:

- Гүйцэтгэгч нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгогдсон Монгол улсын нутаг дэвсгэрт харилцаа холбооны үйлчилгээний сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.
- Гүйцэтгэгч нь угсралтын ажлыг эхлэхээс өмнө төлөвлөгөө боловсруулж, ДҮТ ТӨХХК-ийн Мэдээлэл холбооны албаны инженерээр хянуулж зөвшөөрөл авсан байна.
- Гүйцэтгэгч нь угсралт, суурилуулалт, засварын ажлыг бүрэн дууссаны дараа гүйцэтгэлийн ажлын хүлээлцсэн акт, ажлын зураг, холбогдох бичиг баримтыг боловсруулан захиалагчид хүлээлгэн өгнө.
- Захиалагч нь худаг, сувагчлалын засварын ажилд хяналт тавин, зааварчилгаа өгч хамтран ажиллана.
- Гүйцэтгэгч нь захиалагчийн тавьсан техникийн тодорхойлолтод нийцсэн бараа материалыг тоо ёсоор нийлүүлэхээс гадна, суурилуулалтын явцад үүссэн бараа материалыг хариуцан нийлүүлнэ.
- Гүйцэтгэгч нь газар шорооны ажил хийх, шилэн кабель татах ажил гүйцэтгэхдээ аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу угсарч суурилуулах ба инженер техникийн ажилтануудынхаа аюулгүй байдлыг бүрэн хариуцна.
- Тендер шалгаруулалтанд оролцох хүсэлтэй байгаа эрх бүхий хуулийн этгээд нь холбооны худаг, сувагчлал, ажлын цар хүрээтэй танилцах зорилгоор ажлын байран дээр өөрийн биеэр ирж танилцаж болно.
- Холбооны инженерийн байгууламжийн угсралт суурилуулалтын ажлыг Монгол улсын Телефон сүлжээний кабелийн худаг, техникийн ерөнхий шаардлага MNS5016:2001, телефон сүлжээний сувагчлалд зориулсан хуванцар яндан MNS 5017:2001, шилэн кабелийн залгаа хийх, муфьтлэх ерөнхий шаардлага MNS 5278:2014 стандартуудыг баримтлан хийж гүйцэтгэнэ.

Шаардлагатай материалын жагсаалт:

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Маяг	Нэгж	Тоо	Техникийн үзүүлэлт, шаардлагууд
1	Худгийн ширмэн таг, хүзүүвчтэй	-	ш	12	25тн даацтай, цоожтой байна
2	Худгийн бетон таг, хүзүүвчтэй	-	ш	6	10тн даацтай, цоожтой байна
3	Цемент	OPC 42.5	тн	1	Евро стандартын цемент
4	Хайрга	-	тн	2	Нарийн ширхэгтэй 0,5 хайрга
5	Сувагчлалын шилэн кабель 24 кор	24C, G652D	м	300	Сувагчлалаар татах зориулалттай байна

6	Шилэн кабелийн муфьт	Joint Box	ш	2	24 корын шилэн кабель гагнах зориулалттай байна
7	Кабелийн бирк	-	ш	40	Худаг дотор шилэн кабельд ашиглах зориулалттай ган бирк байна
8	Машин механизм, тээврийн зардал	-	багц	1	Ажил гүйцэтгэх үеийн машин механизм тоног төхөөрөмжийн тэвээрлэлтэд зориулагдсан зардал гэж ойлгоно
9	Ажиллах хүчний зардал	-	багц	1	Ажил гүйцэтгэх үеийн ажиллах хүчний зардал гэж ойлгоно